

СЗХ
он 2023 сар 01 өдөр
БҮРТГЭВ
№ 01

0000001
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
“Өрийн хэрэгслийн бүртгэлийн журам”-ын
Хавсралт 4-а
БҮРТГЭВ-03

АЛБАН МЭДЭГДЭЛ

Улаанбаатар бонд

Огноо: 2023/08/23

Энэхүү Албан мэдэгдэл нь нийтэд санал болгон бонд гаргах Улаанбаатар хот /Нийслэл/-ын үйл ажиллагааны ерөнхий стратеги төлөвлөгөө, татаан төвлөрүүлсэн хөрөнгөөр санхүүжүүлэх үйл ажиллагаа, түүний Монгол улсын Засгийн газар /Нийслэлийн баримталж байгаа бодлогод нийцсэн байдал, мөн тэдгээрийн хэрэгжилт, үр дүн, хөрөнгийн зарцуулалттай холбоотой мэдээллийг тайлагнахтай холбоотой төлөвлөгөөг хөрөнгө оруулагч, холбогдох талуудад толилуулах зорилготой юм.

1. Ерөнхий мэдээлэл

1.1.	Бонд гаргагч аймаг/нийслэл хотын нэр:	Нийслэлийн Засаг Дарга
1.2.	Бонд гаргахтай холбоотойгоор гаргасан Иргэдийн төлөөлөгчдийн хурлын шийдвэрийн огноо, дугаар:	Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 08 сарын 09-ний өдрийн 97 тоот тогтоол
1.3.	Засгийн газраас олгосон зөвшөөрлийн огноо, дугаар:	Монгол улсын Засгийн газрын 2023 оны 07 сарын 19-ний өдрийн 282 тоот тогтоол
1.4.	Бондын нэр:	Улаанбаатар бонд
1.5.	Зэрэглэл /зэрэглэл тогтоолгосон бол/:	Зэрэглэл тогтоолгоогүй
1.6.	Зэрэглэл тогтоосон байгууллагын нэр /зэрэглэл тогтоолгосон бол/:	Зэрэглэл тогтоолгоогүй
1.7.	Тоо ширхэг:	5,000,000 (таван сая) ширхэг хүртэл
1.8.	Нэрлэсэн үнэ:	100,000 (зуун мянга) төгрөг

2023 08 23



1.9. Хугацаа:

5 жил хүртэл

/Хөтөлбөрийн хүрээнд хэсэгчлэн санал болгох бондуудын хүү, хугацаа, санал болгох хугацаа болон бусад нөхцөлийг тухай бүр Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч шийдвэрлэнэ./

1.10. Хүү, төрөл /тогтмол, хөвөгч г.м/:

Тогтмол болон хөвөгч хүүтэй

Хүүгийн дээд хязгаар: Бодлогын хүү + 5 хүртэл хувь

/Хөтөлбөрийн хүрээнд хэсэгчлэн санал болгох бондуудын хүү, хугацаа, санал болгох хугацаа болон бусад нөхцөлийг тухай бүр Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч шийдвэрлэнэ./

1.11. Хүү, үндсэн төлбөр төлөх давтамж, хугацаа:

Хүү төлөх давтамж: Хагас жил тутам

Үндсэн төлбөр төлөх хуваарь:

Хугацааны эцэст

Анхдагч зах зээлийн арилжааг хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулах ба хэсэгчлэн санал болгох тухай бүр өмчлөх эрхийн бүртгэл хийгдсэн өдрөөс эхлэн хүүг тооцож эхэлнэ.

Хүү тооцох аргачлал:

- Жилийн хүүг 365 хоногоор тооцох бөгөөд хүү хуваарилан олгох өдөр амралтын өдөр таарсан тохиолдолд тухайн өдрөөр тасалбар болгон хүүг тооцож, дараагийн ажлын өдөр төлнө;
- Хугацааны эцэст үндсэн болон хүүгийн төлбөр хуваарилан олгогдох өдөр амралтын өдөр таарсан тохиолдолд өмнөх ажлын өдрөөр тасалбар болгон эзэмшсэн хугацааны хүүг тооцож, тус өдрөөр үндсэн болон хүүгийн төлбөрийг төлнө.

Хөвөгч хүүтэй бондын хувьд:

- Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв дээр өмчлөх эрхийн бүртгэл хийгдэх өдрөөс өмнөх ажлын 5 хоногоор тасалбар болгон, тухайн үеийн Монголбанкнаас зарласан бодлогын хүүг суурь болгож, Нийслэлийн Засаг даргын 5 хүртэл хувийн хязгаарт шийдвэрлэсэн хүүгийн түвшнийг нэмсэн байдлаар эхний 6 сарын хүүг тооцож олгоно;

2023 -09- 01

БҮРТГЭВ-03

СЗХ
от 2023.09.01 өдөр
БҮРТГЭВ
№ 01

1.12. Бусад нөхцөл /хугацаанаас өмнө хөрөнгө оруулагч эргүүлэн худалдах, бонд гаргагч худалдаж авах нөхцөлтэй г.м/:

- Дараагийн хагас жил тутамд тооцох хүүг ээлжит хүүгийн төлөлт хийгдэх өдрөөс өмнөх ажлын 5 хоногоор тасалбар болгон тухайн үеийн Монголбанкнаас зарласан бодлогын хүүг суурь болгож, Нийслэлийн Засаг даргын 5 хүртэл хувийн хязгаарт шийдвэрлэсэн хүүгийн түвшинг нэмсэн байдлаар тухай н хагас жилийн хүүг тооцно.

1.13. Татан төвлөрүүлэхээр төлөвлөсөн мөнгөн хөрөнгийн хэмжээ:

-
500,000,000,000 (таван зуун тэрбум) төгрөг хүртэл*

*Бондын татан төвлөрүүлсэн үнийн дүнгээс тухай бүр андеррайтерийн шимтгэлийг суутган тооцно.

1.14. Тодорхой ўе шаттай буюу Бонд гаргах хөтөлбөр хэрэгжүүлэх дэлгэрэнгүй мэдээлэл:

Бондыг СЗХ-ны “Өрийн хэрэгслийн бүртгэлийн журам”-ын 4.3.1-д заасны дагуу 24 хүртэлх сарын хугацаатай бондын хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. Хөтөлбөрийн хүрээнд хэсэгчлэн санал болгох тухай бүр бондуудын хүү, хугацаа, санал болгох хугацаа болон бусад нөхцөлийг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч шийдвэрлэнэ.

Санхүүгийн зохицуулах хорооны “Өрийн хэрэгслийн бүртгэлийн журам”-ын 6.5-д заасны дагуу бондыг анхдагч зах зээлд санал болгож, захиалгыг эхлүүлэх тухай мэдэгдлийг уг ажиллагааг эхлүүлэхээс ажлын таваас доошгүй өдрийн өмнө Хороонд мэдэгдэнэ.

1.15. Стратегийн хөрөнгө оруулагч болон/эсхүл олон нийтэд санал болгон худалдахаар төлөвлөсөн хугацаа:

Санхүүгийн зохицуулах хорооны “Өрийн хэрэгслийн бүртгэлийн журам”-ын 4.3-д заасны дагуу Бондын анхны нийлүүлэлтийг Хороонд бүртгүүлснээс 6 сарын дотор, үлдэх дүнг хөтөлбөрийн хугацаанд багтаан санал болгоно. Зах зээлийн нөхцөл байдал болон хөрөнгө оруулагчдын хандлагыг харгалзан Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн тухай бүр шийдвэрлэсний дагуу тус

2023.08.27



журмын 6.5-д тусгаснаар бондыг анхдагч зах зээлд санал болгож, захиалгыг эхлүүлэх тухай мэдэгдлийг уг ажиллагааг эхлүүлэхээс ажлын таваас доошгүй өдрийн өмнө Хороонд мэдэгдэж анхдагч зах зээлийн арилжааг зохион байгуулна.

- 1.16. Үнэт цаасаар гэрчлэгдэх хөрөнгө оруулагчийн эрх, үүрэг:

Бонд эзэмшигчийн эрх, үүрэг:

- Анхдагч зах зээлээс худалдан авсан бондоо хоёрдогч зах зээл дээр чөлөөтэй худалдах эрхтэй.
- Бондын үндсэн болон хүүгийн төлбөрийг заасан хуваарийн дагуу бүрэн төлөхийг Үнэт цаас гаргагчаас шаардах эрхтэй бөгөөд тус эрхээ өөрөө эсхүл төлөөлөгч, өмгөөлөгчөөр дамжуулан эдэлнэ.
- Бондтой холбоотой аливаа санал, гомдлыг Андеррайтерт мэдэгдэнэ.
- Бонд эзэмшигч нь хуулиар хүлээсэн татвар, арилжааны шимтгэл болон бусад гарах зардлыг өөрөө хариуцна.
- Бонд эзэмшигчийн бондын захиалгын төлбөрт төлсөн мөнгөн хөрөнгө нь түүний хууль ёсны үйл ажиллагаанаас олсон орлого бөгөөд “Мөнгө угаах, терроризмтой тэмцэх тухай хууль”-ийн дагуу холбогдох шалгуурыг хангасан, эрх зүйн аливаа доголдолгүй, маргаангүй байна.
- Бондын үндсэн нөхцөлүүдийг бүрэн хүлээн зөвшөөрч, албан мэдэгдэл болон бусад холбогдох мэдээлэлтэй танилцсаны үндсэн дээр хөрөнгө оруулалтын шийдвэрийг гаргана.
- Хууль, тогтоомжид заасан бусад эрх, үүрэг.

- 1.17. Андеррайтер, үнэт цаас гаргахтай холбоотойгоор мэргэжлийн үйлчилгээ үзүүлж байгаа бусад этгээд, тэдгээртэй байгуулсан гэрээгээр хүлээсэн эрх, үүрэг, хариуцлага:

Андеррайтер нь Үнэт цаас гаргагч “Улаанбаатар хот”-ын бонд санал болгон гаргах ажиллагаанд 2023 оны 08 сарын 18-ны өдөр андеррайтерийн гэрээ байгуулсан. “Андеррайтерийн зөвлөх үйлчилгээний гэрээ”-ний хүрээнд талууд дараах эрх, үүрэгтэй байна:

Зөвлөх /Андеррайтер/-ийн эрх, үүрэг:

- Зөвлөх нь энэхүү гэрээнд заасан үйл ажиллагааг Монгол Улсын хууль тогтоомжид

СЗХ
ом. 2023.09.01
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-09-01
БҮРТГЭВ-03

НИЙЦҮҮЛЭН МЭРГЭЖЛИЙН ТҮВШИНД ХИЙЖ
ГҮЙЦЭТГЭНЭ.

- Зөвлөх нь үнэт цаас гаргах ажиллагааг амжилттай зохион байгуулах үүднээс шаардлагатай бүхий л хүчин чармайлтыг гарган (best effort) нөхцөлөөр ажиллана.
- Үнэт цаас гаргагчийн үнэт цаасны данс нээх, бүртгүүлсэн үнэт цаас байршуулах ажлыг зохион байгуулах зэргээр брокерын үйлчилгээ үзүүлэх үүрэгтэй.
- Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны нийлүүлэлт болон арилжааг гүйцэтгэх үүрэгтэй.
- Зөвлөх нь хөрөнгө оруулагчийн шийдвэр гаргахад шаардлагатай үнэт цаас гаргагчийн талаарх хуулиар хориглосноос бусад бүхий л мэдээллийг үнэт цаас гаргагчаас гаргуулан авах боломжтой.

Захиалагч /Үнэт цаас гаргагч/-ийн эрх, үүрэг:

- Захиалагч нь үйлчилгээний зорилгоор СЗХ, МХБ-д үнэт цаасыг бүртгүүлэхэд шаардагдах бүхий л материалыг Зөвлөхөд гаргаж өгөх үүрэгтэй.
 - Хөрөнгө оруулагчдын хууль ёсны эрх ашгийг чухалчлан үзнэ.
 - Татан төвлөрүүлсэн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулах үүрэгтэй.
 - Үнэт цаас гаргагчийн эрх бүхий этгээдийн баталсан үнэт цаасны нөхцөлийн дагуу үндсэн болон хүүгийн төлбөрийг заасан хугацаанд төлөх үүрэгтэй.
 - Үнэт цаас гаргагч нь зөвлөх компанийд үнэт цаасны данс нээж, үнэт цаастай холбоотой аливаа арилжаа, гүйлгээг зөвлөхөөр гүйцэтгүүлнэ.

1.18. Анхдагч зах зээлд санал болгох арга, хэлбэр:

- Арилжаа эрхлэх байгууллагаар дамжуулан тогтсон үнийн аргаар олон нийтэд санал болгох
- Андеррайтерийн компаниар дамжуулан дараах аргаар олон нийтэд санал болгох
 - Захиалгын бүртгэлийн арга
 - Тогтсон үнийн арга

8 23
2023



2023 8 23

2. Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

- 2.1. Улаанбаатар /Нийслэл/ хот нь үнэт цаас гаргах замаар татан төвлөрүүлсэн хөрөнгөөр дараах төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр төлөвлөсөн.
- 2.1.1. Үйл ажиллагаа – 1
- 2.1.1.1. *Нийслэлийн төсвийн хөрөнгөөр он дамжин хэрэгжиж буй сургууль, цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэх төсөл, арга хэмжээ*
- 2.1.1.2. Төсөвт өртөг, татан төвлөрүүлсэн хөрөнгөнд эзлэх хувь: 100 тэрбум төгрөг хүртэл буюу 20.0% хүртэл
- 2.1.1.3. Хэрэгжүүлж эхлэх, дуусах болон нийт хугацаа: 2022-2024 он
- 2.1.1.4. Хэрэгжүүлэгч этгээд:
- Орон нутаг
 - Хувийн хэвшил
 - Төр, хувийн хэвшлийн түншлэл
- 2.1.1.5. Бэлэн байдлын үнэлгээ
- Зураг төсөл
 - Техник, эдийн засгийн үнэлгээ
 - Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ
 - Туслан гүйцэтгэгч
 - Бусад мэргэжлийн байгууллагаас гаргасан дүгнэлт
 - Шаардлагатай бусад
- 2.1.1.6. Тухайн үйл ажиллагаа нь төр, орон нутгийн бодлого, стратегид нийцсэн байдал, нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөө, хүрэх үр дүн, учирч болзошгүй эрсдэл зэрэг болон бусад дэлгэрэнгүй мэдээлэл



Нийслэлийн бодлого стратегид нийцсэн байдал:

- ✓ *Алсын хараа-2050*

Зорилт 9.1.1. 2021-2030 онд Нийгмийн үйлчилгээний байгууллагуудын (сургууль, цэцэрлэг, эрүүл мэнд, биеийн тамир, спортын байгууллага, запуучууд хөгжлийн төв, хүүхэд хамгаалах төв, асрамжийн газар гэх мэт) хүчин чадал, хүртээмжийг нэмэгдүүлж бүтээн байгуулалт хийж, шаардлагатай техник, тоног төхөөрөмжөөр хангана.

- ✓ *Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл:*

2.1.8. Газар зүйн мэдээллийн системд үндэслэн сургууль, цэцэрлэг, дотуур байрны хүчин чадал, ашиглалт, бүтэц, хэв шинж, байршлыг

СЭХ
он 2023.09.01
сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

2023-09-01

БҮРТГЭВ-03

оновчтой тогтоож, хүн амын өсөлтийн хэтийн төлөвтэй уялдуулан хүртээмжийг нэмэгдүүлэн, тэгш байдлыг хангах тогтолцоог бэхжүүлнэ.

✓ *Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр:*

2.3.9. Суралцагчдад ээлтэй сургалтын орчныг бүрдүүлж, хүртээмжийг нэмэгдүүлэх, тусгай хэрэгцээт хүүхдийг ердийн сургууль, цэцэрлэгт сурах, хөгжих боломжийг нэмэгдүүлэх зорилгоор бүтээн байгуулалтыг хийнэ.

✓ *Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл:*

2.2 Хүүхэд бүрийг сургуулийн өмнөх боловсролд хамрагдах, бага боловсрол эзэмшихэд бэлтгэх нөхцөлөөр хангана.

2.3 Хүүхэд бүрийг төлбөргүй, тэгш, чанартай бага болон суурь боловсрол эзэмших нөхцөлийг бүрдүүлнэ.

✓ *Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө*

2.3.2. Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн хүртээмжийг нэмэгдүүлж, барилга ашиглалт, ачааллын коэффициентыг бууруулж, хүүхдийн хөгжлийг бүх талаар дэмжинэ.

Нийгэмд үзүүлэх үр нөлөө:

- Нийслэлийн хэмжээнд 2022-2023 оны хичээлийн жилд төрийн өмчийн 158, төрийн бус өмчийн 138, нийт 296 ерөнхий боловсролын сургуульд 364,488 суралцагч суралцаж, сургуулийн өмнөх боловсролын төрийн өмчийн 289, төрийн бус өмчийн 360, нийт 649 цэцэрлэгийн 4,196 бүлэгт 127,278 хамрагдсан байна.
- Одоогийн байдлаар үйл ажиллагаа явуулж байгаа төрийн өмчийн сургууль, цэцэрлэгүүдийн олонх нь хүчин чадлаас давсан ачаалалтай хичээллэж байгаа бөгөөд урьдчилсан тооцооллоор сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролд хамрагдах насын хүн амын тооны өсөлтийг авч үзвэл 2024 он гэхэд цэцэрлэгт хамрагдах хүүхдийн тоо 142 мянга, ерөнхий боловсролын сургуульд хамрагдах хүүхдийн тоо 384 мянгад хүрэхээр байгаа нь сургууль, цэцэрлэгийн эрэлт, хэрэгцээ шаардлага өндөр байгааг харуулж байна.
 - Нийслэлийн хэмжээнд улс, нийслэл, дүүргийн төсөв, гадаадын зээл, тусlamжийн хөрөнгөөр он дамжин хэрэгжиж буй болон 2023 онд шинээр хэрэгжихээр батлагдсан 47 сургууль, 88 цэцэрлэг, 25 бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор, 3 спорт заал, 1 дотуур байр, нийт 164 боловсролын байгууллагын хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ хэрэгжиж байна. Үүнээс 25 төсөл арга хэмжээ нь 2018-2020 онд хэрэгжиж эхэлсэн ажил байгаа бөгөөд магадлалаар батлагдсан төсөв, нэмэлт хөрөнгө, үнийн индекс зэргээс хамаарч төсөв дутагдсан эсвэл гүйцэтгэгчээс шалтгаалан ажил удааширсан байна.

2023 0 23

СЗХ
2023.09.01
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-09-01
БҮРТГЭВ-03

- Засгийн газрын 2021 оны 05 сарын 19-ний өдрийн "Нийслэл Улаанбаатар хотын талаар авах зарим арга хэмжээний тухай" 146 дугаар тогтоол, Засгийн газрын 2022 оны 05 сарын 31-ний өдрийн "Нийслэлийн цэцэрлэгийн хүртээмжийг сайжруулах талаар авах зарим арга хэмжээний тухай" 218 дугаар тогтоол зэрэг шийдвэрүүдээр нийгэм, эдийн засгийн ач холбогдол бүхий томоохон төслийг хэрэгжүүлэх үүргийг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчид даалгасны дагуу хэрэгжүүлэн ажиллаж байгаа.

Энэ хүрээнд Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 2023 онд цэцэрлэг, сургуулийн хүртээмжийг нэмэгдүүлэхээр нийт 218.6 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 57 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх ажлыг эхлүүлж 2024 онд ашиглалтад оруулахаар төлөвлөн ажиллаж байна. Эдгээр төсөл, арга хэмжээнд 2023 онд 12.5 тэрбум төгрөгийг нийслэлийн төсөвт тусгасан. Үлдэгдэл төсвийг нийслэлийн төсөвт шийдвэрлэж чадахгүй нөхцөл байдал үүсэж, ашиглалтад оруулах хугацаа хойшлох, ингэснээр инфляцын нөлөө, үнийн өсөлт, нэмэлт хөрөнгийн асуудал зэргээс хамаарч төсөвт нэг сургууль, цэцэрлэг барих төсөв 1.5-2.0 дахин нэмэгдэж, төсөвт үргүй зардал бий болоод байгаа юм.

Иймд дээрх 57 төсөл, арга хэмжээг бүрэн ашиглалтад оруулахад нийт 201.1 тэрбум төгрөг шаардлагатай. Үүнээс 137.2 тэрбум төгрөгийн өртөг бүхий нэн шаардлагатай 36 төсөл арга хэмжээ (4 сургууль, 10 цэцэрлэг, 7 бага сургууль-цэцэрлэгийн цогцолбор, 11 Монгол өв уламжлал, ёс заншлын өргөөг барих, 4 цэцэрлэг худалдан авах)-г 2020-2023 оныг дамнан хэрэгжүүлж байна. Эдгээр сургууль, цэцэрлэгийг бүрэн ашиглалтад оруулахад 105.6 тэрбум төгрөгийн санхүүжилт шаардлагатай.

Хүрэх үр дүн:

Сургууль, цэцэрлэгийн шаардлагатай санхүүжилтийг шийдвэрлэж, төлөвлөсөн хугацаанд ашиглалтад оруулснаар дараах үр дүнд хүрэх боломжтой.

- ✓ Нэмж 3,605 хүүхдийг цэцэрлэгт хамруулах, сургуулийн хүчин чадлыг 5,300 хүүхдийн тоогоор нэмэгдүүлэх, нийт 8,905 орчим хүүхдийг ая тухтай, хамран сургах тойротг буюу гэрийнхээ ойролцоо сурх нөхцөлийг бүрдүүлнэ.
- ✓ Хүүхдээ сургууль, цэцэрлэгт хүргэх авто замын хөдөлгөөнд оролцогчийг төдий хэмжээгээр бууруулж, авто замын ачааллыг багасгана.
- ✓ Сургууль, цэцэрлэгийн анги, бүлэг дүүргэлтийн хүүхдийн тоо нормативт хэмжээнээс хэтэрсэн сургууль, цэцэрлэгийн ачааллыг бууруулна.
- ✓ Сургуулийн барилгын ашиглалтын коэффициентийг 1.48-д хүргэнэ.

2023 8 23

2023 -09- 01

0000009



БҮРТГЭВ-03

- ✓ 2023-2024 оны хичээлийн жилд нийслэлийн хэмжээнд 3 ээлжинд шилжих нөхцөл үүссэн өрөнхий боловсролын 47 сургуулийн ачааллыг бууруулж, нэмж 33,380 суралцагч, 16,690 суудлын тоог бий болгох боломж бүрдэнэ.



Учирч болзошгүй эрсдэл:

- Байгалийн давагдашгүй хүчин зүйл /бороо, цас/, цаг агаарын нөхцөл байдлаас хамаарч төсөл, арга хэмжээ хугацаандаа хэрэгжихгүй байх.
- Барилгын бараа материалын үнийн өсөлт, тээвэрлэлтийн тогтвортгүй байдал эрсдэл үүсгэх боломжтой.

2.1.2. Үйл ажиллагаа – 2

2.1.2.1. Нийслэлийн инженерийн дэд бүтцийн хүртээмж, авто зам, замын байгууламжийн сүлжээг нэмэгдүүлэх төсөл, арга хэмжээ

2.1.2.2. Төсөвт өртөг, татан төвлөрүүлсэн хөрөнгөнд эзлэх хувь: 72.5 тэрбум төгрөг хүртэл буюу 14.5 хувь хүртэл

2.1.2.3. Хэрэгжүүлж эхлэх, дуусах болон нийт хугацаа: 2023-2024

2.1.2.4. Хэрэгжүүлэгч этгээд:

- Орон нутаг
- Хувийн хэвшил
- Төр, хувийн хэвшлийн түншлэл

2.1.2.5. Бэлэн байдлын үнэлгээ

- Зураг төсөл
- Техник, эдийн засгийн үнэлгээ
- Байгал орчны нөлөөллийн үнэлгээ
- Туслан гүйцэтгэгч
- Бусад мэргэжлийн байгууллагаас гаргасан дүгнэлт
- Шаардлагатай бусад

2.1.2.6 Тухайн үйл ажиллагаа нь төр, орон нутгийн бодлого, стратегид нийцсэн байдал, нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөө, хүрэх үр дүн, учирч болзошгүй эрсдэл зэрэг болон бусад дэлгэрэнгүй мэдээлэл:



Нийслэлийн бодлого стратегид нийцсэн байдал:

- ✓ Алсын хараа-2050

Зорилт 9.3.3. 2021-2030 онд инженерийн дэд бүтцийн хүчин чадлыг нэмэгдүүлж, шинэ технологийг нэвтрүүлсэн байна.

Зорилт 9.5.1. 2041-2050 онд Дагуул, хаяа хот, тосгон тус бүрд нь худалдаа, үйлчилгээ, соёл боловсрол, хөдөө аж ахуй, хүнс, хөнгөн

2023 8 23

2023 -09- 01

БҮРГЭВ-03

СЗХ
2023.09.01
БҮРГЭВ
№ 01

үйлдвэрлэл, тээвэр логистик, аялал жуулчлалын чиглэлээр төрөлжүүлэн хөгжүүлж ажлын байрыг нэмэгдүүлэх замаар Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулсан байна.

- ✓ *Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл*
2.2 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих буюу ажлын байрыг нэмэгдүүлж, ядуурлыг бууруулах зорилт, төлөвлөгөөтэй нийцэж байна.
9.19 Авто зам, дугуйн зам, явган замын нөхцөлийг сайжруулан, гол, туслах гудамж болон хорооллын доторх замыг өргөтгөх, шинэчилж, авто замыг шинээр барьж, үндсэн сүлжээг нэмэгдүүлэн хөгжүүлнэ.
- ✓ *Нийслэлийн 2021-2024 оны стратеги төлөвлөгөө*
2.2 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих буюу ажлын байрыг нэмэгдүүлж, ядуурлыг бууруулах;
3.8 Усны бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлэх хүрээнд цэвэр ус, бохир усны шугам болон хаягдал ус зайлцуулах байгууламж, үерийн далан, суваг тэдгээрт хамааралтай барилга байгууламжийн төлөвлөлт, ашиглалт, хяналтын ажлыг гүйцэтгэх;
10.1 Хотын дэд бүтцийн бодлогыг хэрэгжүүлж, инженерийн байгууламжийн ашиглалтын найдвартай ажиллагааг хангах хүрээнд шинээр байгуулах дэд бүтэц, цэвэрлэх байгууламж, үерийн далан, суваг шуудуу барих, Нийслэлийн ус, дулааны төвлөрсөн бус инженерийн хангамжийн үйл ажиллагааг хангана.

Нийгэмд үзүүлэх үр нөлөө:

- Тухайн замыг явган зам, дугуйн зам, ногоон байгууламжтай, стандарт нормын дагуу зөв зохистой төлөвлөснөөр иргэдийн эрүүл аюулгүй амьдрах нөхцөл боломжийг бүрдүүлэхээс гадна зорчигчдын тав тухтай байдлыг хангана. Мөн энэхүү зам нь түгжрэлийг бууруулахад хувь нэмэр оруулна.
- Нийслэл хотын агаарын бохирдлыг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах, иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах зорилгоор нийслэлийн 8 дүүргийн 28 байршилд 85 хэсэгчилсэн талбайд гэр хорооллын газрыг дахин төлөвлөх, барилгажуулах төслийг хэрэгжүүлэхээр баталсан.
Энэхүү төлөвлөгөөний дагуу 148,323 айлын орон сууц баригдах тооцоо гарсан. Иймд тэдгээр орон сууцны цахилгаан, дулааны холболт, цэвэр, бохир усны холболт гэх мэт инженерийн дэд бүтцийн асуудлыг бүхлээр нь шийдвэрлэх шаардлага үүссэн. Үүнтэй холбоотойгоор инженерийн дэд бүтцийн асуудлыг шийдвэрлэх, тэдгээрийн авто замын холболт, дэд бүтцийн асуудлыг давхар шийдвэрлэхээр авто замын сүлжээ, шугам сүлжээний холболт, өргөтгөл, хүчин чадлыг нэмэгдүүлэхэд нөлөөлөхөөр байна.
- Дэд бүтцийн төлөвлөлт нь иргэдийн аюулгүй, эрүүл тухтай орчинд амьдрахад хамгийн чухал хүчин зүйл бөгөөд үерийн аюулыг авч үзэхэд 2023 оны 07 сарын 01-ний өдрөөс 07 сарын 07-ны өдрүүдэд орсон борооны улмаас 31,600 өрхийн 128,000 орчим иргэд, 108 барилга байгууламж, 11 зам үерт авсан. Иймд үерийн далан, ус

2023 8 23



зайлуулах хоолой гэх мэт дэд бүтцийн асуудлыг богино хугацаанд шийдвэрлэх нь иргэдийн амь нас, эд хөрөнгө, аюулгүй байдлыг хамгаалах нэн тэргүүнд гүйцэтгэнэ.

- Мөн нийслэлийн үерийн хамгаалалтын далан сувгийн 36 хувийнх нь насжилт хэтэрч, ус зайлуулах шугам сүлжээний 22 хувийнх нь ашиглалтын хугацаа дууссан статистик гарсан. Үүнээс гадна Сэлбэ сэргэлт төслийн хүрээнд үерийн усны түвшинг тогтоо судалгаа хийгдэж байгаа ба Сэлбэ, дунд голын баруун болон зүүн далангаар үерийн ус халих байршуудыг тогтоосон ба Сэлбэ голын Нарны замын гүүр хүртэлх далангаар хальсан үерийн ус хотын төвийн ихэнх хэсгийг усанд автуулахаар байгаа дүгнэлтэд хүрсэн. Иймд дэд бүтцийн асуудлыг яаралтай шийдвэрлэх нөхцөлд хүрсэн.
- Үйлдвэрлэл технологийн парк барьснаар Улаанбаатар хотын төвлөрлийг бууруулах, Налайх, Багануур дүүргийн эдийн засгийг сайжруулахаас гадна тухайн бүс нутагт ажлын байрыг нэмэгдүүлэх давуу талыг бий болгоно.



Хүрэх үр дүн:

- ✓ Баянзүрх дүүргийн 14 дүгээр хороонд төлөвлөж буй уг зам нь нэг чигийн хөдөлгөөний урсгалтай үерийн сувгийн далангийн 2 талаар зорчих хэсэг, ногоон байгууламж, явган хүний зам бүхий Энхтайваны өргөн чөлөөнөөс урагш Нарны замыг холбосноор Энхтайвны өргөн чөлөө, Нарны зам, зүүн 4 замын уулзварын хөдөлгөөний ачааллыг хуваарилах ач холбогдолтой нутаг дэвсгэрийн туслах гудамж, зам болно.
- ✓ Дотоодын барилгын материал үйлдвэрлэл 1.8 дахин нэмэгдэх;
- ✓ 5,000 гаруй ажлын байрыг нэмэгдүүлэх;
- ✓ Суурьшлын шинэ бүс байгуулах замаар Улаанбаатарын төвлөрлийг бууруулах;
- ✓ Олон улсын стандартад нийцсэн төрөлжсөн барилгын материалын үйлдвэрийн бүс бий болгох.



Учирч болзошгүй эрсдэл:

- Мэргэжлийн боловсон хүчиний дутагдал;
- Зах зээлийн нөхцөл байдал, түүхий эдийн үнээс хамаарч төсөвт дүнд өөрчлөлт орох буюу зардал нэмэгдэх.

2.1.3. Үйл ажиллагаа – 3

2.1.3.1. Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах хүрээнд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ

2.1.3.2. Төсөвт өртөг, татан төвлөрүүлсэн хөрөнгөнд эзлэх хувь: 177.5 тэрбум төгрөг хүртэл буюу 35.5 хувь хүртэл

2.1.3.3. Хэрэгжүүлж эхлэх, дуусах болон нийт хугацаа: 2023 – 2024 оны өвлийн улиралд

2023 8 23

2.1.3.4. Хэрэгжүүлэгч этгээд:

- Орон нутаг
- Хувийн хэвшил
- Төр, хувийн хэвшлийн түншлэл

2.1.3.5. Бэлэн байдлын үнэлгээ:

- Зураг төсөл
- Техник, эдийн засгийн үнэлгээ
- Байгал орчны нөлөөллийн үнэлгээ
- Туслан гүйцэтгэгч
- Бусад мэргэжлийн байгууллагаас гаргасан дүгнэлт
- Шаардлагатай бусад

Дараах 5 лабораторид түлшний техникийн үзүүлэлтийг тодорхойлох, галлагааны үед ялгарах утаанд агуулагдах хорт хийн хэмжээг тодорхойлох шинжилгээнүүдийг хийлгэсэн.

a. Техникийн үзүүлэлт:

- Ашигт малтмал, газрын тосны газрын Уул уурхай, газрын тосны төв лаборатори
- Хими, хими технологийн хүрээлэнгийн лаборатори
- "Эс жи эс" ХХК-ийн лаборатори (SGS)

b. Утааны үзүүлэлт:

- Нийслэлийн агаар, орчны бохирдолтой тэмцэх газрын лаборатори,
- Дулаан техник, үйлдвэрлэлийн экологийн хүрээлэнгийн лаборатори

2.1.3.6 Тухайн үйл ажиллагаа нь төр, орон нутгийн бодлого, стратегид нийцсэн байдал, нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөө, хүрэх үр дүн, учирч болзошгүй эрсдэл зэрэг болон бусад дэлгэрэнгүй мэдээлэл:



Нийслэлийн бодлого стратегид нийцсэн байдал:

✓ **Алсын хараа-2050**

Зорилт 2.5.2. 2021-2030 онд Агаар, ус, хөрс, дуу чимээний бохирдлыг багасгаж, цэвэр, ногоон бүхий орчинтой болно.

✓ **Тогтвортой хөгжлийн зорилт**

Зорилт 11.6. 2030 он гэхэд агаарын чанар, хотын болон хог хаягдлын менежментийн асуудалд онцгой анхаарлаа хандуулах замаар хотуудын нэг хүнд ногдох байгаль орчны сөрөг нөлөөллийг бууруулах /Улаанбаатар хотыг утаагүй болгох/;

✓ **Засгийн газрын хөгжлийн бодлого, стратеги**

Монгол улсын Засгийн газрын 2017 оны 98 дугаар тогтоол "Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр";

Монгол улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр

тогооолын 5.1.1-д Улаанбаатар хотын агаарын бохирдлыг 80 хувь хүртэл бууруулж, бусад томоохон хот, суурин газрын агаарын бохирдлын асуудлыг үе шаттайгаар шийдвэрлэх;

✓ *Нийслэлийн 2021-2024 оны стратеги төлөвлөгөө*

7.1 Авто замын түгжрэлийг бууруулах, нийтийн тээврийн үйлчилгээний төрөл, чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, нийслэл хотод тулгамдсан бусад асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

Нийгэмд үзүүлэх үр нөлөө:

- Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах, арилгах нь нийслэлийн эн тэргүүнд шийдвэрлэх асуудал бөгөөд энэхүү асуудлыг шийдвэрлэхээр олон улсын туршлагыг судлан хэрэгжүүлж ирсэн. Лондон, Сөүл, Бээжин зэрэг хотууд нь Улаанбаатартай ижил нөхцөлд орж байсан ба агаарын бохирдлыг бууруулахын тулд дараах 3 арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байдаг:
 - Түүхий нүүрсний хэрэглээг хязгаарлах, зогсоох;
 - Боловсруулсан нүүрсэн түлш, хагас коксон түлшийг хэрэглээнд нэвтрүүлэх;
 - Хийн түлшинд шилжих.
- Монгол улсын Засгийн газрын 2018 оны 62 тоот тогооолоор Улаанбаатар хотод айл өрх, аж ахуй нэгжүүдийг түүхий нүүрс түлэхийг хориглож, сайжруулсан түлшийг нэвтрүүлсэн. Сайжруулсан түлш хэрэглэснээр нийслэлийн агаарын бохирдол 2 дахин буурсан хэдий ч тоосонцор, хүхэрлэг хийн хэмжээ агаарын чанарын стандартаас өндөр байсаар байна.
Иймд хийн хангамжийн дэд бүтэц байгуулахад урт хугацаа шаардах тул богино хугацаандaa хагас коксон түлшийг хэрэглээнд нэвтрүүлэх нь зүйтэй хэмээн шийдвэрлэсэн.
Энэ хүрээнд хагас коксон түүхий эдээр үйлдвэрлэсэн шахмал түлшийг хэрэглээнд нэвтрүүлэх боломжийг судлах зорилгоор Эрчим хүчний сайдын 2023 оны А/94 дүгээр тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг хагас коксон түлш үйлдвэрлэх үйлдвэрлэлийн туршилтын ажил зохион байгуулахаар төлөвлөгөө гарган ажиллаж байна.
- Лабораторийн шинжилгээний дүнгээр 100% хагас коксоор үйлдвэрлэсэн шахмал түлшний техникийн үзүүлэлт болон хаягдал утаанд агуулагдах хорт хийн үзүүлэлт хамгийн сайн үр дүн харуулсан. Энэхүү 100% хагас коксоор үйлдвэрлэсэн шахмал түлштэй техникийн үзүүлэлт нь мидлингээр үйлдвэрлэсэн шахмал түлштэй харьцуулахад дэгдэмхий 45.8%, хүхэр 57.7%, үнслэг чанар 37.2%-иар тус тус бага бөгөөд хаягдал утаанд агуулагдах тоосонцрын хэмжээ 72.6%, хүхэрлэг хийн хэмжээ 85.5%, угаарын хийн хэмжээ 10.8%, азотын исэл 23.5% хүртэл тус тус багассан.
- Шахмал түлшийг уламжлалт аргаар буюу мод болон бусад зориулалтын бус материал ашиглан асааж байгаа нь агаарт дэгдэх

СЗХ
2023.09.01
сар. өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
0000014
2023-09-01
БҮРТГЭВ-03

тоосонцрын хэмжээг нэмэгдүүлдэг. Галлагааны үеийн тоосонцрыг бууруулах зорилгоор зориулалтын асаагч ашиглах нь зүйтэй бөгөөд тэдгээр асаагч нь дөлжих чадвар өндөр, үнэргүй, тоосонцор болон хорт хийн ялгаралгүй байх шаардлагатай. Монголд үйлдвэрлэсэн асаагчуудад хийсэн лабораторийн шинжилгээгээр агаарт ялгарах хорт хийн агууламжууд нь MNS 5216:2016 стандартын шаардлагыг хангасан. Иймд “Таван толгой түлш” ХХК-ийн үйлдвэрлэсэн асаагчуудыг зах зээлд нийлүүлэх боломжтой.

Зориулалтын асаагч, 100% коксоор үйлдвэрлэсэн шахмал түлшийг хэрэглээнд нэвтрүүлснээр Улаанбаатар хотын гол тулгамдаж буй асуудал болох агаарын бохирдлыг хэмжээг бууруулна гэж Эрчим хүчний яам үзсэн.



Хүрэх үр дүн:

2023-2024 оны өвлийн улиралд 100% хагас коксоор үйлдвэрлэсэн сайжруулсан түлшийг айл өрх хэрэглэснээр Улаанбаатар хотын агаарын чанарын үзүүлэлт 2022 оны мөн үетэй харьцуулахад дараах байдлаар буурах боломжтой.

- ✓ Агаарт хаягдах тоосонцрын хэмжээ: 72.6% хүртэл;
- ✓ Хүхэрлэг хийн хэмжээ: 85.5% хүртэл;
- ✓ Угаарын хийн хэмжээ: 10.8% хүртэл;
- ✓ Азотын исэл: 23.5% хүртэл.



Учирч болзошгүй эрсдэл:

Тус төслийг хэрэгжүүлэхэд дараах эрсдэлүүд учирч болзошгүй.

- Зориулалтын асаагчуудыг ашиглаагүйгээс үүдэн шахмал түлш асахгүй байгаа, удаан халж байгаа тухай хэрэглэгчдийн зүгээс ирэх сөрөг хандлага ихсэж, шахмал түлшний хэрэглээ буурах буюу төлөвлөсөн хэмжээнээс бага байх;
- БНХАУ-аас түүхий эд татан авч байгаатай холбоотой тээвэр, логистикийн тасалдал, удаашрал;
- Зах зээл дэх нүүрсний үнийн хэлбэлзлээс шалтгаалан тооцоолсноос өндөр үнээр авах.

- 2.1.4. Үйл ажиллагаа – 4
- 2.1.4.1. Сэлбэ, Дунд голын дагуу үерийн гамшгаас сэргийлж, далан байгуулах, Улаанбаатар хотын авто замын сүлжээний нэвтрүүлэх чадварыг сайжруулж, түгжрэлийг бууруулах зорилгоор хэрэгжүүлж буй Сэлбэ сэргэлт төслийн эхний ээлжийн бүтээн байгуулалтын санхүүжилт
- 2.1.4.2. Төсөвт өртөг, татан төвлөрүүлсэн хөрөнгөнд эзлэх хувь: 150 тэрбум төгрөг хүртэл буюу 30.0 хувь хүртэл
- 2.1.4.3. Хэрэгжүүлж эхлэх, дуусах болон нийт хугацаа: 2023-2025 он
- 2.1.4.4. Хэрэгжүүлэгч этгээд:

2023 өвлийн
үйлдвэрлэсэн
тоосонцрын
хааны
хэмжээ



- Орон нутаг
- Хувийн хэвшил
- Төр, хувийн хэвшлийн түншлэл

2.1.4.5. Бэлэн байдлын үнэлгээ

- Зураг төсөл
- Техник, эдийн засгийн үнэлгээ
- Байгал орчны нөлөөллийн үнэлгээ
- Туслан гүйцэтгэгч
- Бусад мэргэжлийн байгууллагаас гаргасан дүгнэлт
- Шаардлагатай бусад

Нийт ажлын гүйцэтгэл 53 хувьтай байгаа бөгөөд эдгээрийг үйл ажиллагаа тус бүрээр задлан харвал:

- Усны барилга байгууламжийн ажил - 49 хувь;
- Зам гүүрний зураг төслийн гүйцэтгэл – 30 хувь;
- БОНУ – 63 хувь;
- Инженер Геологийн судалгаа – 45 хувь;
- Геодези, зураг зүйн ажил – 95 хувь;

ТЭЗҮ, Ерөнхий төлөвлөгөө, тохижилтын ажил – 40 хувьтай байна.

2.1.4.6. Тухайн үйл ажиллагаа нь төр, орон нутгийн бодлого, стратегид нийцсэн байдал, нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөө, хүрэх үр дүн, учирч болзошгүй эрсдэл зэрэг болон бусад дэлгэрэнгүй мэдээлэл:



Нийслэлийн бодлого стратегид нийцсэн байдал:

- ✓ *Алсын хараа-2050*
Зорилт 9.3.1. 2021-2030 онд Улаанбаатар хотын төвлөрөл, суурьшсан нутаг дэвсгэрийн тэлэлт, хязгаарлалт, газар зохион байгуулалт, авто замын сүлжээ, нийтийн тээвэр, газар доорх орон зайн шаардлагатай төлөвлөлтийг тооцон хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулж, мэдээллийн нэгдсэн системд холбон хот байгуулалтын үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.
- ✓ *Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл*
9.19 Авто зам, дугуйн зам, явган замын нөхцөлийг сайжруулан, гол, туслах гудамж болон хорооллын доторх замыг өргөтгөх, шинэчилж, авто замыг шинээр барьж, үндсэн сүлжээг нэмэгдүүлэн хөгжүүлнэ.
- ✓ *“Нийслэлийн Засаг дарга Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө*
6.3.1.1 Гол, туслах гудамж замыг шинээр барьж, өргөтгөн шинэчилнэ.
6.3.2.1 Хорооллын чанартай авто замыг шинээр барьж, засвар шинэчлэлт хийнэ.
6.3.4.2 Явган зорчигчийн гүүрэн гарцыг авто зам болон төмөр зам дээгүүр барина.

2023 -09- 01

БҮРТГЭВ

СЗХ
2023.09.01
он сар, өдөр
БҮРТГЭВ
№ 01

6.3.4.3 Авто машины болон явган зорчигчийн нүхэн гарцуудыг барина.

6.3.7 Явган хүний болон дугуйн зам шинээр барина.

Нийгэмд үзүүлэх үр нөлөө:

- Сэлбэ голын тэжээлийн 69 хувийг хур борооны ус, 5 хувийг цас, мөсний ус, 26 хувийг ул хөрсний ус эзэлдэг бөгөөд газар хөдлөлийн 8 баллын бүсэд оршдог. Сэлбэ голын дагуу 9 км газарт далан, түшиц ханыг хийсэн ч үлдсэн 70 хувь нь ил задгай урсаж байгаа нь хөрсний бохирдолд өртөх, үерийн эрсдэлийг нэмэгдүүлж байна.
Иймд Сэлбэ голын дагуу дэд бүтэц, инженерчлэлийн ажлыг хийж гүйцэтгэх зайлшгүй шаардлага үүссэн. Сэлбэ сэргэлт төслийг хэрэгжүүлснээр Дамбадаржаагийн цэцэрлэгт хүрээлэнгээс Сонсголонгийн гүүр хүртэл авто зам замын трассын дагуу дүүргийн чанартай хүрээлэн 2, автобусны буудал дагасан бичил тохижилт 24, голын далан доторх иргэдийн ая тухай амрах боломжтой бичил тохижилтуудыг хийхээр төлөвлөсөн.
- Мөн баруун уулын сувгийн гүүр, наадамчдын гудамж дахь гүүр, ажилчдын гудамж дахь гүүр, авто буудлагын зам дээрх гүүр, энгельсийн гүүр зэрэг 5 гүүрийг засварлах, Сэлбэ-Дамбадаржаагийн бүсэд үерийн усны тооцоог хийх, Сонсголонгийн гүүрнээс Олимп гүүр хүртэлх инженер-геологийн ажлыг тус тус гүйцэтгэхээр төлөвлөсөн.
- Сэлбэ, Дунд голын дагуу үерийн гамшигаас сэргийлж, далан байгуулах, Улаанбаатар хотын авто замын сүлжээний нэвтрүүлэх чадварыг сайжруулж, түгжрэлийг бууруулах зорилгоор хэрэгжүүлж буй Сэлбэ сэргэлт төслийн эхний ээлжийн бүтээн байгуулалтад шаардлагатай 150 тэрбум төгрөг байна.
- Энэхүү төслийг хэрэгжүүлснээр дараах чиглэлээр нийгэмд эзэр нөлөөтэй. Үүнд:
 - Үерийн эрсдэлийг бууруулах
 - Авто замын түгжрэлийг бууруулах
 - Нийтийн тээврийн хүртээмжийг нэмэгдүүлэх
 - Унадаг дугуйн хэрэглээг дэмжих
 - Хотын явган хүний замын сүлжээг нэмэгдүүлэх
 - Гол дагуух хөндлөн замын сүлжээг хөгжүүлэх
 - Авто машины хэрэглээг бууруулах
 - Гол дагуух тохижилт
 - Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд ажиллаж амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ
 - Хотын эко системийг тэнцвэржүүлэх
 - Голын урсцыг нэмэгдүүлэх
 - Хөрсний бохирдлыг бууруулах
 - Агаарын бохирдлыг бууруулах
 - Газар чөлөөлөлтийн зардал багатай

2023 8 23

- Гол дагуу инженерийн шугам сүлжээг хонгилын системд шилжүүлж гэр хорооллын барилгажилтыг дэмжих



Хүрэх үр дүн:

Төслийн хүрээнд шинээр 21.6 км авто замыг бий болгож голын хоёр талын суурьшил, худалдаа үйлчилгээний хэсгүүдийг холбосон 18 туслах гүүр, одоо байгаа авто замын сүлжээ дээгүүр 4 гүүрэн байгууламж, 9 нүхэн гарцыг загварчлалаас сонгож хэрэгжүүлэх боломжтой. Ингэснээр хорооллын чанартай ашиглалт муутай 63 уулзвар гарцын хөдөлгөөний эрчмийг дэмжиж төв зам дагуух авто замын түгжрэл буурна.



Учирч болзошгүй эрсдэл:

- Байгалийн гэнэтийн үер усны эрсдэл
- Санхүүжилтийн үе шатнаас хамааран төсөл удаашрах
- Газар чөлөөлөлт болон инженерийн шугам сүлжээг шилжүүлэх, хамгаалахтай холбоотой эрсдэл
- Үнийн өсөлт

2.2 Удирдлага, хэрэгжүүлэх үйл ажиллагааны удирдлагын систем, бүтцийн тухай

Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн 20 дугаар зүйлд заасны дагуу Нийслэл хотын удирдлага дараах тогтолцоотой байна.

- Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал
- Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч.
- Нийслэлийн Засаг дарга нь Улаанбаатар хотын Захирагч байх бөгөөд ажлын албатай байна.
- Нийслэл хотын удирдлага шийдвэр гаргахдаа Монгол Улсын Засаг захирагаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 31 дүгээр зүйлийг баримтална.

Нийслэлийн Засаг даргын ажлын алба нь Нийслэлийн Засаг даргын Тамгын газар байна.

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 360 тоот тогтоолоор Нийслэлийн агентлаг харьяа газар, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын бүтэц бүрэлдэхүүн Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны бүтэц, Дүүргийн засаг даргын тамгын газар, Улаанбаатар хотын захирагчийн ажлын албаны орон тоог баталсан.

Төсвийн тухай хууль болон холбогдох хууль, эрх зүйн хүрээнд Улс, нийслэлийн бодлогын баримт бичигт тусгагдсан төсөл, арга хэмжээнүүдийг тухайн жилийн батлагдсан төсвийн хүрээнд хэрэгжүүлдэг.

Төрийн болон орон нутгийн өмчийн бараа ажил, үйлчилгээг худалдан авах тухай хуулийн дагуу Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газраас тендер зарлаж, тухайн тендерт шалгарсан аж ахуйн нэгж байгууллагатай ажил үйлчилгээ гүйцэтгэх гэрээг Нийслэлийн Засаг даргын захирамжаар олгогдсон эрхийн дагуу холбогдох газрын удирдлага байгуулна.

СЗХ
он 2023 сар 09. 01
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН ЕМРК
MONGOLIAN STOCK EXCHANGE
00000018
2023 -09- 01
БҮРТГЭВ-03

Мөн Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 14.4 дэх хэсэг, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах хуулийн холбогдох хэсгийг үндэслэн Нийслэлийн Засаг даргын захирамж гарч холбогдох агентлаг захиалагчийн хяналт, тавьж ажиллана.

Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын зүгээс Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоол болон Нийслэлийн Засаг даргын 2022 оны 1106 дугаартай журмын хүрээнд хэрэгжилтийн үйл ажиллагааны тайланг сар, улирал бүр гаргаж шилэн данс болон өөрийн вэб сайтаар дамжуулан нийтэд мэдээллэж ажиллана.

2.3 Хориглох үйл ажиллагааны жагсаалт

Нийслэл нь Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль, Төрийн удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль болон бусад холбогдох хууль, журамд зааснаас бусад үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно.

Улаанбаатар хот /Нийслэл/ нь Санхүүгийн зохицуулах хорооны “Өрийн хэрэгслийн бүртгэлийн журам”-ын 3.4.5-д заасны дагуу энэхүү мэдэгдэлд тусгасан төсөл, арга хэмжээ болон бонд гаргахтай холбоотой гарах зардлаас бусад үйл ажиллагааг тус бондын татан төвлөрүүлсэн хөрөнгөөр санхүүжүүлэхгүй.

2.4. Чөлөөт хөрөнгийн удирдлагатай холбоотой мэдээлэл

Нийслэл нь татан төвлөрүүлсэн хөрөнгийн төлөвлөлт, зарцуулалтыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс төсөл тус бүрээр тайлагнаж ажиллана.

Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, Төрийн сангийн хэлтэс нь бондын хөрөнгийн зарцуулалтын ил тод байдлыг хангаж ажиллана.

Улаанбаатар бондын татан төвлөрүүлсэн эх үүсвэр үлдэгдэлтэй байгаа нөхцөлд хөрөнгө оруулалтын арга хэмжээг дахин төлөвлөж, төсөвт тусган батлуулж зарцуулна.

2.5 Шаардлагатай бусад мэдээлэл:

-

3. Тайлagnal

3.1. Тайлангийн нэр, олон нийтэд хүргэх хэлбэр, давтамж

Тайлангийн нэр: Зарцуулалтын тайлан

Олон нийтэд хүргэх хэлбэр, давтамж:

Нийслэл нь бондын арилжааг хийсэн өдрөөс тухайн бондын хугацаа дуусах хүртэлх хугацаанд татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайланг Санхүүгийн зохицуулах хорооны “Өрийн хэрэгслийн бүртгэлийн журам”-ын хавсралт 8-д тусгасан маягтуудын дагуу улирал тутамд дараа сарын 10-ны өдрийн дотор, жилийн тайланг дараа оны 02 сарын 10-ны дотор, Хороо, санхүү, төсвийн

2023 8 23

СЭХ
ОН 2023 САР 09. 01
БҮРТГЭВ
№ 01

2023 -09- 01

БҮРТГЭВ-03

асуудал эрхэлсэн төрийн байгууллага, арилжаа эрхлэх байгууллагад тус тус хүргүүлж, нийтэд мэдээлнэ.

Тайлангийн нэр: Хэрэгжүүлэх үйл ажиллагааны хэрэгжилтийн тайлан, мэдээлэл Нийслэлийн үнэт цаасыг 24 сар хүртэлх хөтөлбөрийн хүрээнд хэсэгчлэн нийтэд санал болгох ба Санхүүгийн Зохицуулах Хорооны “Өрийн хэрэгслийн бүртгэлийн журам”-ын 6.6-д тусгасны дагуу анхдагч зах зээлийн арилжааг зохион байгуулах мэдэгдэлд энэхүү баримт бичигт тусгасан хэрэгжүүлэх үйл ажиллагааны хэрэгжилтийн тайлан мэдээллийг хавсарган хүргүүлнэ.

3.2. Хэрэгжүүлэх үйл ажиллагааны явц, үе шат, үр дүнг илэрхийлэх чанарын болон тоон үзүүлэлтүүд

Бондын татан төвлөрүүлсэн хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээний явц, үе шат, үр дүнг дараах журмын хүрээнд холбогдох хэлтсүүд үнэлэн, хяналт тавьж, нийтэд мэдээлж ажиллана.

- Монгол улсын Засгийн газрын 2020 оны 206 тоот тогтоолын “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам болон “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх журам”-д заасны дагуу хяналт шалгалт, үнэлгээ хийнэ.
- “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх журам” нь Хөгжлийн бодлогын баримт бичиг болон хууль тогтоомж, шийдвэрийн хэрэгжилтийг нийслэлийн нутаг дэвсгэрт зохион байгуулах, тэдгээрийн хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн, нийслэлийн захиргааны байгууллагын үйл ажиллагааг үнэлж, дүгнэхтэй холбогдсон харилцааг зохицуулдаг.
- Санхүүгийн Зохицуулах Хорооны “Өрийн хэрэгслийн бүртгэлийн журам”-ын 6.6-д тусгасны дагуу анхдагч зах зээлийн арилжааг зохион байгуулах мэдэгдэлд энэхүү баримт бичигт тусгасан үйл ажиллагааны хэрэгжилтийн тайлан мэдээллийг хавсарган Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржид хүргүүлж, нийтэд тухай бүр мэдээлнэ.

3.3. Үйл ажиллагааны тайлан хариуцсан ажилтан /алба, нэгж/-ны холбоо барих хаяг, утас, цахим хаяг

Овог нэр: Нямдорж овогтой Наранбаатар

Албан тушаал: НЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга

Хаяг: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 7-р хороо, 87-19 тоот

Утас: +976-99107176

Цахим хаяг: naranbaatar.n@ulaanbaatar.com

2023 09 23

БАТАЛГААЖУУЛАЛТ

1. Овог, нэр:
СҮМЬЯАБАЗАР

Албан тушаал: Нийслэлийн Засаг дарга
бөгөөд Улаанбаатарт хотын Захирагч

Гарын үсэг:

(Тамга/тэмдэг)

Долгорсүрэн

2. Овог, нэр: **Данзан ДАЯНБИЛГҮҮН**

Албан тушаал: Андеррайтер “Бидисек
ҮЦК” ХК-ийн ТУЗ-ийн дарга бөгөөд
Ерөнхийлөгч

Гарын үсэг:

(1115205447 ± 2052482)

Тамга/тэмдэг)

3. Овог, нэр: **Ичинноров БААТАРХҮҮ**

Албан тушаал: Нийслэлийн Засаг даргын
Тамгын газрын дарга

Гарын үсэг:

(Тамга/тэмдэг)

4. Овог, нэр: **Нямдорж НАРАНБААТАР**

Албан тушаал: Нийслэлийн Засаг даргын
Тамгын газрын Санхүү, Төрийн сангийн
хэлтсийн дарга

Гарын үсэг:

(Тамга/тэмдэг)

ТТБ ± 2105

27.02.2022

УЛААНБААТАР ХОТ

МХБ-ийн гишүүн
Андеррайтер
Брокер дилерийн
“БИДИСЕК”
ҮЦК ИК

1115205447 ± 2052482